



ШУДАРГА ИРГЭДИЙН  
НЭГДСЭН ЭВСЭЛ НАМ-д

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.22. № 181.  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хандивын тайлангийн дүгнэлт**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Тухайн намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулаагүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

**Дүгнэлтийн үндэслэл**

Аймаг дахь Төрийн аудитын газар Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.


## Дүгнэлт

**ШУДАРГА ИРГЭДИЙН НЭГДСЭН ЭВСЭЛ НАМ** нь 2020 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

“Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам”-аас ирүүлсэн хандивын тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт..... хуудас

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН

Нам, эвсэлээс ирүүлсэн хандивын тайланг хянан  
баталгаажуулж дүгнэлт гаргах зааврын хавсралт

МАЯГТ-1

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвсэлд "Иргэн"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт  
"Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл" намын Өвөрхангай аймгийн Орон нутгийн зөвлөл

/мян.төг/

Д/д	Иргэний овог нэр	Хандив өгсөн иргэний мэдээлэл				Хандив өгсөн огноо	Хандивын мөнгөн дүн	Хандив хүлээн авсан		Тайлбар
		Регистрийн дугаар	Нас	Оршин суугаа хаяг	Утасны дугаар			Банкны нэр	Дансны дугаар	
Ээлжит сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон										
2019 онд Иргэн-ээс хандивын орлого ороогүй болно. /2020 онд данс нээгдсэн болно./										
Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд										
2020.01.01-2020.06.01 хүртэл хугацаанд Иргэнээс хандивын орлого ороогүй болно.										

Савамж: Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-г заасан иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивт намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамааруулахгүй.



*Нямсхан Дорж*  
албан тушаал

*М. Оюунзүл*  
овог нэр

*М. Оюунзүл*  
гарын үсэг

2020.06.19

Нам, эвсэлээс ирүүлсэн хандивын тайланг хянан  
баталгаажуулж дүгнэлт гаргах зааврин хавсралт

МАЯГТ-2

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвсэлд "Хуулийн этгээд"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт  
"Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл" намын Өвөрхангай аймгийн Орон нутгийн зөвлөл

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээлэл				Хандив хүлээн авсан			Мөнгөн дүн	Тайлбар
		Регистрийн дугаар	Хаяг, утасны дугаар	Үүсгэн байгуулагдсан огноо	Үйл ажиллагааны чиглэл	Хуулийн этгээдийн хэлбэр	Огноо	Банкны нэр		
<b>Ээлжит сонгуулийн жилийн өмнөх 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон</b>										
2019 онд Хуулийн этгээдээс хандивын орлого ороогүй болно. /2020 онд данс нээгдсэн болно./										
<b>Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд</b>										
2020.01.01-2020.06.01 хүртэл хугацаанд Хуулийн этгээдээс хандивын орлого ороогүй болно.										

Санамж: Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивт намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамааруулахгүй.



/Хуулийн намын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, албан ёсны тамга тэмдгээр баталгаажуулна./

*Ганзориг Бадарх*  
албан тушаал

*М. Оюунзуул*  
овог нэр

*М. Оюунзуул*  
гарын үсэг

2020.06.19